

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ
МЭЙЖОР ДРИЛЛИНГ МОНГОЛ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Улаанбаатар

2026 он

АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТАНИЛЦУУЛГА.....	1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО.....	1-1
1.3 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.3.1 Агуулахын байршил, орчны тойм зураг.....	1-1
1.4 ҮНДСЭН БАЙГУУЛАМЖ.....	1-2
1.5 АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ.....	1-6
1.6 ДЭД БҮТЭЦ.....	1-10
1.7 ХОГ ХАЯГДАЛ.....	1-10
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2-1
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТЗ- 1	
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	3-1
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	3-1
3.3 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....	3-1
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-1
4.1 ГОЛ ЗОРИЛТ.....	4-1
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ.....	4-1
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-1
4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-6
4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-6
4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-6
4.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-7
4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	4-10
4.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-12
4.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-13
ДҮГНЭЛТ А	
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	В

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Зөвшөөрөлтэй химийн бодисын нэр төрөл, CAS дугаар.....	1-6
Хүснэгт 1-2. Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын тооцоо.....	1-10
Хүснэгт 4-1: 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй.....	4-1
Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	4-3
Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	4-6

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4-7
Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	4-9
Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	4-11
Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4-12
Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	4-14
Зургийн жагсаалт	
Зураг 1-1. Агуулахын байршил.....	1-1
Зураг 1-2. Мэйжор дриллинг монгол ХХК-ийн барилга, байгууламж.....	1-2
Зураг 1-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим	1-3
Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар	1-3
Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар	1-3
Зураг 1-6. Оффис доторх галын булан.....	1-4
Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө	1-4
Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах газар	1-4
Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа	1-5
Зураг 1-10. Химийн бодисын сав баглаа боодол.....	1-5
Зураг 1-11. Химийн бодисын агуулахын агааржуулалт	1-6
Зураг 1-12. Засварын цех	1-6
Зураг 4-1. Орчны хяналт шинжилгээний цэгүүд	4-13

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2021.10.08 өдрийн 13/4714 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2022 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд түсгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Химийн бодисын агуулахын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд 2026 оны БОМТ нь 2022 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 5 дах жилийн БОМТ, 2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 2 дох жилийн БОМТ юм.

БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТАНИЛЦУУЛГА

1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Химийн бодисын агуулах
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Мэйжор дриллинг монгол ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019012091 Регистрийн дугаар: 2704358 Хаяг: Улаанбаатар хот - 17061, Хан-Уул, 3-р хороо, Ажилчдын гудамж Утас: 70119951 +976 99111293 Цахим шуудан: ulzii.chuluun@majordrilling.com


1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Мэйжор дриллинг монгол ХХК нь өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудыг тусгай зөвшөөрөл бүхий ханган нийлүүлэгчээс худалдан авч, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Шинэст ХК-ийн эзэмшлийн химийн бодисын агуулахыг түрээслэн түр хадгалан, цаашид Оюу Толгой ХХК болон бусад захиалагч компаниудын өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулахад химийн бодисуудыг хэрэглэнэ.

1.3 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.3.1 Агуулахын байршил, орчны тойм зураг

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах нь Хан-Уул дүүргийн 3-р хороонд үйлдвэрийн бүсэд байрлана. Агуулахын байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Агуулахын байршил

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн барилга нь үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд төслийн барилгын хойд талд Витафит үйлдвэр, урд талд Гоё тараг үйлдвэр, замын эсрэг талд Дулааны 3-р цахилгаан станц, УБЦТС-ын баруун түгээх төв тус тус байрлана.

1.4 ҮНДСЭН БАЙГУУЛАМЖ

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах нь оффисын барилга болон засварын цех, химийн бодисын агуулах гэсэн үндсэн 3 байгууламжаас бүрдэнэ.



Оффисын барилга



Химийн бодисын агуулах



Засварын цех

Зураг 1-2. Мэйжор дриллинг монгол ХХК-ийн барилга, байгууламж

Оффис. Оффисын барилга дотор аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг өрөө, ажилчдын гал тогоо, цайны газар, хувцас солих өрөө зэрэг байна. Оффист химийн бодисын агуулахад ажиллах үед ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг тусгай танхим байна.



Зураг 1-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим



Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар



Ажилчдын цайны газар



Ажилчдын гал тогоо

Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар



Зураг 1-6. Оффис доторх галын булан



Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө



Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах газар

Химийн бодисын агуулах :

Химийн бодисын агуулахын барилга нь 34.2м² талбайтай, цэвэр бохир ус, дулаан нь төвийн нэгдсэн шугамд холбогдсон, механик агааржуулалттай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр

гадаргуутай, анхааруулах тэмдэг, дохио үг, санамж болон шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг ил байршуулсан байна.



Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа



Зураг 1-10. Химийн бодисын сав баглаа боодол

Химийн бодисын агуулахын тавиур, бодисын сав баглаа боодол нь Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд (Монгол улсын шадар сайд, байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт) заасан химийн бодисын тавиур нь доорх шаардлагыг хангаж байна. Тухайлбал:

- Химийн бодисын тавиур нь шатамхай биш, химийн бодист тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн, тогтвортой хөдөлгөөнгүй суурилагдсан
- Тавиур дээр хураасан бодис гулсаж унахаас хамгаалсан хаалттай
- Тавиур нь хэт өргөн биш, хураасан бодис нүдэнд ил харагдахаар, хүрч болохуйц өргөнтэй байна.



Зураг 1-11. Химийн бодисын агуулахын агааржуулалт



Зураг 1-12. Засварын цех

1.5 АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ

Мэйжор дриллинг монгол ХХК нь олон тооны захиалагч компаниудын хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэн зэс, алт, нүүрс, уран, поташ болон усны өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэх бөгөөд алмазан, чиглэлт, урвуу эргэлтэт, усны болон далд уурхайн өрөмдлөг зэрэг 28 өрмийн машинтайгаар өрөмдлөгийн үйлчилгээг гүйцэтгэдэг байна. Өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудын Зөвшөөрөлтэй химийн бодисын нэр төрөл болон шинээр нэмэгдэж буй химийн бодисын нэр төрөл, хэмжээ, CAS дугаар, зориулалтыг Хүснэгт 1-1-д тусгав.

Хүснэгт 1-1. Зөвшөөрөлтэй химийн бодисын нэр төрөл, CAS дугаар

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
1.		Hammer oil 150			1000 л
2.	Өрмийн алхны тос	Hammer oil 320	Highly refined paraffinic oil >60%	5500-88	1000 л
3.	Өрмийн штангийн тос	Amc liquid rod grease	/CH ₂ -O-C(O)-R ₁ /CH-O-C(O)-R ₂ /CH ₂ -O-C(O)-R ₃ /-	7641-44	2000 л
4.	Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/	Amc rod grease xtra tacky	Barium, acetate tallow fatty acid complex hydrocarbon mineral oil (70-80%)	64742-52-5	4000 кг
5.	Өрмийн хошууны тос	Ep bit lube	Refined Vegetable oil /CH ₂ -O-C(O)-R ₁ /CH-O-C(O)-R ₂ /CH ₂ -O-C(O)-R ₃ /-	6921-10-3	4000 л

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
6.	Ургамлын гаралтай тастагчийн тос	Amc universal		7639-46	5000 л
7.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Penetrol xtra		7639-46	800 л
8.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Torque-free xtra		7177-11	800 л
9.	Органик полимер	Austrol	[C ₆ H ₇ O ₂ (OH) ₃ -X(OC ₂ H ₅)X] _n 100% ethylcellulose	9004-57-3	15 тн
10.	Шингэн полимер	AMC-liquid pol	Drilling fluid additive	60815	15 тн
11.	Сэргээх полимер	AMC-CR-650	Drilling fluid additive, 100%	4902-92	45 тн
12.	Полимер, өсдөг	AMC-AUS PLUG	Cross-linked polyacrylamide, 100%	9003-05-8	2000 кг
13.	Нийлэг ко-	AUS-floc	Co-Polymer	4902-93	800 л
14.	полимер	AUS-floc blocks		6089-06	768 кг
15.	Цэвэрлэгч полимер	Well clean	Sodium carboxymethyl cellulose, 100%	7758-16-9	480 кг
16.	Полимер, цавуулаг	AMC PAC-L	Sodium carboxymethyl cellulose, 100%	9004-32-4	15 тн
17.		AMC PAC-R			100 тн
18.		EZEE PAC-R			100 тн
19.	Өрөмдлөгийн цемент	GYP-SET 15	Calcium sulfate hemihydrate	10034-76-1	2000 кг
20.		GYP-SET 30			2000 кг
21.	Шингэн цемент	FR-100L	Naphthalenesulfonic acids	68153-01-5	800 л
22.	Цементийн нэмэлт	AMC XXX 10	Calcium chloride 80%	10043-52-4	320 кг
23.		AMC XXX 15	fly ash-low quartz 20%	68131-74-8	480 кг
24.	Өрөмдлөгийн хөөс	Super foam	Anionic surfactants, 60%	7177-08	800 л
25.	Өрөмдлөгийн нийлэг хөөс	AUS GRIP A Eco	Polyethylene/polypropylene/glycol glyceryl ether	9082-00-2	548.1 кг
26.		AUS GRIP B Eco	Polymeric diphenylmethane diisocyanate	9016-87-9	81.9 кг
27.	Өрөмдлөгийн тэнцвэржүүлэгч	AMC ground stabilizer	Vinyl acetate homopolymer 30-60%	9003-20-7	800 л
28.	Өрөмдлөгийн хагарал тогтоогч	Fracseal	Micronised organic cellulose fiber, 100%	9004-34-6	875 л
29.	Өрмийн угаалгын шингэн	AMC Truck	Detergent blend, 100 %	7639-45	800 л
30.	Концентратат цэвэрлэгч бодис	AUS DET XTRA	Nonhazardous ingredients, 60	7732-18-5	800 л
31.	Ус ангижруулагч	Soda ash	Sodium carbonate, 99%	497-19-8	1000 кг
32.	Кальцийн хлорид	Calcium chloride	Calcium chloride, 85%	10043-52-4	1000 кг
33.	Газрын давс	Potassium chloride	Potassium chloride, 99% KCL	7447-40-7	10 тн
34.	Өрөмдлөгийн ус ангижруулагч	AMC water conditioner	EDTA tetrasodium salt 75%, sodium carbonate 25%	64-02-8 497-19-8	480 кг
35.	Барийн сульфат	Barite	Barium sulfate	7727-43-7	1200 кг
36.	Ус алдалт тогтоогч	Shur seal	Shredded paper	42071	200 кг

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
37.	Филтрекс	Filtrex	Ingredients determined to be hazardous >90	9003-20-7	2000 кг
38.	Өрмийн шингэн найруулагч	Ausgel	N/A	N/A	2000 кг
39.	Супер Поли Өрөмдлөгийн полимер	Super Poly	C8H14Cl2N2O2 Акрилаци кополимер 30-40%, хөнгөн нефтийн нэрмэл бодис 10-30%, ус 30-70%	N/A	2 тн
40.	Өрмийн шавар	Super Gel	Bentonite (organic clay) 60-100%	1302-78-9	2 тн
41.	Өрмийн товуд	Rod Grease	-	9003-29-6	2 тн
42.	ПЛАГ	Plug	-	9003-004-7	2 тн
43.	Өрмийн тос /усан суурьт дрилл люб/	Drill Lube	(C6H10O5)n	91050-89-4	2 тн
44.	Целлюлоз	CX-Troll	Polysachharide 60-100%	9004-34-6	2 тн
45.	Анионик полимер	CHP Plus	(C7H12O2C5H8O2*C4H6O2)x Акрилет кополимер 90-95%	25035-69-2	2 тн
46.	Ургамлын гаралтай уусдаг тос	Super Lube	Triethanolamine <1, sodium sulfate <5	N/A	50 тн
47.	Тос	AMC Thread Grease-DRTG	N/A	N/A	5 тн
48.	Ксантан хүнсний өтгөрүүлэгч	Sino mud Poly XCD	Ксантан бохь 60-90%	11138-66-2	3 тн
49.	Биоцид	AMC Biocide G	Tetrakis (hydroxymethyl) phos [Noniumsulfate <25, ingredients determined not to be hazardous >60	55566-30-08	3 тн
50.	Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч	AUS Defoamer G	N/A	26-5533	3 тн
51.	Цардуул	AMC Aus Dex	Холимог >60	9005-25-8	3 тн
52.	Органик полимер	AMC Ezee troll	Sodium carboxymethyl cellulose (>60%); sodium carbonate (<5%)	N/A	100 тн
53.	Нимбэгийн хүчил	Citric Acid	Citric acid > -96	77-92-9	3 тн
54.	Өндөр чанарын занарын урвал саармагжуулах	Sinomud Kla-stab	Полиамин	9046-10-0	3 тн
55.	Өрөмдлөгийн шингэний нэгдэл	AMC Ben Viscosifier,	Bentonite, >94 %	1302-78-9	3 тн
56.	Өрөмдлөгийн шингэн нэмэлт	AMC Glute 9 AMC Glute 50	Глутральдегид 50%, ус 50%	111-30-8 7732-18-5	3 тн
57.	Натрийн сульфит	Sodium Sulphite Sodium Sulfate Anhydrous	Sodium Sulphite >95	7757-83-7	3 тн

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Химийн томьёо	CAS дугаар	Хэмжээ, жилд
58.	Өрөмдлөгийн нэмэлт шингэн	AMC Quick Seal	Найрлагыг аюулгүй тодорхойлсон, 100%	62-2620	3 тн
59.	Сийл лац	Sinomud Seal	Шааран ноосон эслэг 60-100 %	65996-69-2	3 тн
60.	Натрийн бикарбонат	AMC Sodium Bicarbonate	Sodium bicarbonate >99	144-55-5	3 тн
61.	Цемент түргэн хатаагч, усгүйжүүлэгч нэмэлт	BASF MasterRheobuild 1000NT	Calcium naphthalene sulphonate-formaldehyde condensate (25-50%)	37293-74-6	3 тн
62.	Магнийн оксид	Magnesium Oxide	Магнийн оксид >65 %, кальцийн оксид 1-3 % үлдсэн аюулгүй найрлага	N/A	3 тн
Шинээр нэмэгдэж буй химийн бодисууд					
63.	Натрийн асфальт сульфонат	SAS-Shale Inhibitor	Холимог	-	1.5 тн
64.	Кальцийн гидроксид	Hydrated lime	Ca(OH) ₂	1305-62-0	10 тн
65.	Хувиргасан цардуул	CMS HT	Холимог	Холимог	20 тн
66.	Натрийн карбонат	Caustic Soda	Na ₂ CO ₃	497-19-8	90 тн
67.	Кальцийн карбонат	Calcium carbonate	CaCO ₃	13397-26-7 7732-18-5	80 тн
68.	Цементийн нэмэлт	Halad® 344 cement additive	N/A	N/A	1 тн
69.	Өрөмдлөгийн шаврын нэмэлт	SAS	N/A	14808-60-7	1.5 тн
70.	Эфирт суурилсан тосолгооны материал	Ester Based Lubricant CF	N/A	106168-45-0	5 тн
71.	Полиуретан шахах зуурмаг	AMC hydro EZ grout	-	-	5 тн
72.	Цемент, зуурмагийн нэмэлт	AMC hard set	-	-	5 тн
73.	Цооногийн эргэлт, шингэний алдагдлыг багасгана	AMC BOS FIX	<5% Al ₂ (SO ₄) ₃ >60% Полимер	10043-01-3	5 тн
74.	Целлюлоз	VIS	-	9004-34-6	20 тн
75.	Анионик полимер	AUS-FLOC L	-	9003-05-8	5 тн
76.	Өрмийн угаалгын шингэн	AMC Maxi Wash	Detergent blend, 100 %		800 л
77.	Цооног тогтворжуулагч	AMC Corewell	-	9003-05-8	5 тн
78.	Өрмийн шавар	CX Ben	Bentonite (organic clay) 60-100%	1302-78-9	10 тн

1.6 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан, дулаан, усан хангамж. Мэйжор дриллинг монгол ХХК-ийн химийн бодисын агуулах төслийн барилгын дулаан хангамж нь Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, цахилгаан хангамж нь Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай холбогдсон бөгөөд усан хангамжийн хувьд төвийн шугамд бүрэн холбогдсон байна.

1.7 ХОГ ХАЯГДАЛ

Хатуу хог хаягдал. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах химийн бодисын агуулахад химийн бодисыг ашиглахгүй бөгөөд өрмийн ажил хийх талбай руу тээвэрлэн ашиглана.

Агуулахад 3 хүн ажиллах ба тэдний ахуйн гаралтай хатуу хог хаягдал (цаас, хоолны үлдэгдэл, лааз, шил г.м) гарна. Хог хаягдлын тооцоог хийхдээ 1 хүн өдөрт 0.5кг хаягдал гаргана гэж тооцоолоход өдөрт 1.5 кг, жилд дунджаар 547.5 кг хатуу хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай 2022.09.27 өдөр №18/-3/26 тоот Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээтэй бөгөөд гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлдэг.

Шингэн хаягдал. Ажиллагсдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт ахуйн бохир шингэн хаягдал гарна. Агуулахын барилгын дэргэд оффис байх бөгөөд оффисын барилга нь цэвэр, бохир үс зэрэг нь төвийн нэгдсэн шугамд бүрэн холбогдсон байна.

Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал. Мэйжор дриллинг монгол ХХК-ийн өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглагдах нийт 64 бодисоос шуудай, 14 бодис нь хуванцар савлагаатай байна. Химийн сав баглаа боодлын жилд гарах савны хог хаягдлын тооцоог Хүснэгт 1-2-д тусгав.

Хүснэгт 1-2. Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын тооцоо

№	Монгол нэр	Савлагаа	Хэмжээ (1 жилээр)	Савлагаа	Савны тоо ширхэг
1.	Өрмийн алхны тос	25 л	1000 л	хуванцар	40
2.		25 л	1000 л	хуванцар	40
3.	Өрмийн штангийн тос	25 л	2000 л	хуванцар	80
4.	Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/	17 кг	4000 кг	шуудай	235
5.	Өрмийн хошууны тос	25 л	4000 л	хуванцар	160
6.	Ургамлын гаралтай тастагчийн тос	25 л	5000 л	хуванцар	200
7.	Ургамлын гаралтай тастагчийн тос	25 л	800 л	хуванцар	32
8.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	25 л	800 л	хуванцар	32
9.	Органик полимер	25 кг	5000 кг	шуудай	200
10.	Шингэн полимер	15 кг	5000 кг	шуудай	333
11.	Сэргээх полимер	25кг	5000 кг	шуудай	200
12.	Полимер, өсдөг	15 кг	2000 кг	шуудай	133
13.		8 кг	800 кг	шуудай	100
14.	ниилэг ко-полимер	25 кг	768 кг	шуудай	30.72
15.	Цэвэрлэгч полимер	12 кг	480 кг	шуудай	40
16.		15 кг	768 кг	шуудай	51.2
17.	Полимер, цавуулаг	25 кг	3000 кг	шуудай	120
18.		25 кг	3000 кг	шуудай	120
19.		25 кг	2000 кг	шуудай	80
20.	Өрөмдлөгийн цемент	20 кг	2000 кг	шуудай	100
21.	Шингэн цемент	20 л	800 л	хуванцар	40
22.	Цементийн нэмэлт	25 кг	320 кг	шуудай	12.8
23.		10 кг	480 кг	шуудай	48

№	Монгол нэр	Савлагаа	Хэмжээ (1 жилээр)	Савлагаа	Савны тоо ширхэг
24.	Өрөмдлөгийн хөөс	15 л	800 л	хуванцар	53.3
25.	Өрөмдлөгийн нийлэг хөөс	25 кг	548 кг	шуудай	21
26.		0.87 кг	81.9 кг	шуудай	94
27.	Өрөмдлөгийн тэнцвэржүүлэгч	13 л	800 л	хуванцар	61
28.	Өрөмдлөгийн хагарал тогтоогч	25 л	875 л	хуванцар	35
29.	Өрмийн угаалгын шингэн	25 л	875 л	хуванцар	35
30.	Концентратат цэвэрлэгч бодис	25 л	800 л	хуванцар	32
31.	Ус ангижруулагч	25 кг	1000 кг	шуудай	40
32.	Кальцийн хлорид	25 кг	1000 кг	шуудай	40
33.	Газрын давс	25 кг	1050 кг	шуудай	42
34.	Өрөмдлөгийн ус ангижруулагч	25 кг	480 кг	шуудай	19
35.	Хүндрүүлэгч материал	25 кг	1200 кг	шуудай	48
36.	Ус алдалт тогтоогч	15 кг	200 кг	шуудай	13
37.	Филтрек	25 кг	2000 кг	шуудай	80
38.	Өрмийн шингэн найруулагч	25 кг	2000 кг	шуудай	80
39.	Супер Поли, өрөмдлөгийн полимер	25 кг	2000 кг	хуванцар	80
40.	Өрмийн шавар	25 кг	2000 кг	шуудай	80
41.	Өрмийн товуд	17 кг	2000 кг	хуванцар	117
42.	ПЛАГ	15 кг	2000 кг	хуванцар	133
43.	Өрмийн тос /усан суурьт дрилл люб/ Целлюлоз	25 кг	2000 кг	хуванцар	80
44.	Полисахарид	15 кг	2000 кг	хуванцар	133
45.	Анионик полимер	15 кг	2000 кг	хуванцар	133
46.	Ургамлын гаралтай уусдаг тос	20 кг	5000 кг	хуванцар	250
47.	Тос	20 кг	5000 кг	шуудай	250
48.	Ксантан хүнсний өтгөрүүлэгч	20 кг	1000 кг	шуудай	50
49.	Биоцид	20 кг	1000 кг	хуванцар	50
50.	Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч	20 кг	1000 кг	хуванцар	50
51.	Цардуул	20 кг	1000 кг	шуудай	50
52.	Органик полимер	20 кг	1000 кг	шуудай	50
53.	Нимбэгийн хүчил	20 кг	1000 кг	шуудай	50
54.	Өндөр чанарын занарын урвал саармагжуулах	20 кг	1000 кг	шуудай	50
55.	Өрөмдлөгийн шингэний нэгдэл. Viscosifier.	20 кг	1000 кг	шуудай	50
56.	Өрөмдлөгийн шингэн нэмэлт	20 кг	1000 кг	шуудай	50
57.	Хүхрийн хүчлийн давс	20 кг	1000 кг	шуудай	50
58.	Өрөмдлөгийн нэмэлт шингэн	20 кг	1000 кг	шуудай	50
59.	Seal лац	20 кг	1000 кг	шуудай	50
60.	Содын бикарбонат	20 кг	1000 кг	шуудай	50
61.	Цемент түргэн хатаагч, усгүйжүүлэгч нэмэлт	20 кг	1000 кг	шуудай	50
62.	Магнийн оксид	20 кг	1000 кг	шуудай	50
63.	Натрийн асфальт сульфонат				
64.	Кальцийн гидроксид				
65.	Хувиргасан цардуул				
66.	Натрийн карбонат				
67.	Кальцийн карбонат				
68.	Цементийн нэмэлт				
69.	Өрөмдлөгийн шаврын нэмэлт				
70.	Эфирт суурилсан тосолгооны материал				

№	Монгол нэр	Савлагаа	Хэмжээ (1 жилээр)	Савлагаа	Савны тоо ширхэг
71.	Полиуретан шахах зуурмаг				
72.	Цемент, зуурмагийн нэмэлт				
73.	Цооногийн багасгана	эргэлт, шингэний алдагдлыг			
74.	Целлюлоз				
75.	Анионик полимер				
76.	Өрмийн угаалгын шингэн				
77.	Цооног тогтворжуулагч				
78.	Өрмийн шавар				

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаандаа ашиглах нийт 78 нэр төрлийн химийн бодисоос 64 бодис хатуу, 14 бодис шингэн төлөвтэй байна. Мэйжор Дриллинг Монгол ХХК нь Цэцүүх трэйд ХХК-тай 2023 оны 06-р сарын 05-ны өдөр Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу аюултай хог хаягдал, сав баглаа боодлыг тээвэрлүүлэн, устгуулдаг байна. Мөн Мэйжор дриллинг ХХК нь Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2022.04.25-ны өдрийн 01/473 тоотой Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжээр БОАЖЯ-ны хог хаягдлын мэдээллийн санд бүртгэгдэж, №001626 дугаар авсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газар зүй: Төслийн талбай нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид хамаарна. Хангай-Хэнтийн уулархаг их мужид Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсыг хамран Монгол орны хойд хэсгийг эзлэх ба ойт хээрийн бүсийг эзэлнэ. Газрын гадаргын хувьд энэхүү мужийн ихэнхийг уул нурууд эзэлнэ. Энэ их мужид багтах Хангайн нуруу нь баруун хойноос зүүн урагш, Хэнтийн нуруу нь зүүн хойноос баруун урагш чиглэнэ. Хангайн-Хэнтийн уулархаг их мужийг газрын гадаргын онцлог, газарзүйн байрлалаар нь дотор нь Хангайн, Хэнтийн, Хөвсгөл орчмын уулсын гэж 3 дэд мужид хуваана.

Уур амьсгал: Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд дунд Туул голын хөндийд байрладаг. Өндөр уулсын муж болон уулс хоорондын хөндий, газрын гадаргуугийн өндөршлийн зөрөө ихэвчлэн 400-500м боловч заримдаа 700-920м хүрдэг. Төв хэсэг нь далайн түвшнээс дээш 1300 м өндөр бөгөөд хотын баруун тийшлэх тутам намсаж III цахилгаан станцын орчимд далайн түвшнээс 1274м өргөгдсөн байдаг. Богдхан уул дархан цаазат газар нь уур амьсгалын хувьд хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай, чийглэгдүү, сэрүүн, нэн хүйтэн мужид хамаарагддаг. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн хам нөлөөгөөр цөлжилт, байгалийн гамшгийн давтагдал нэмэгдэх, усны нөөц биологийн элдэв зүйл хомсдох, газрын чадавх доройтох явц ажиглагдаж улс орны нийгэм, эдийн засагт төдийгүй байгалийн нөхөн сэргээгдэх нөөцөд сөргөөр нөлөөлж байгаа билээ. Агаарын бохирдолд байгаль, цаг агаарын нөхцөл маш их нөлөөлдөг ба өөрөөр хэлбэл агаарын үрсгал, температур, инверсийн өндөр, эрчимшилээс хамаарч агаарын чанар өөрчлөгддөг.

Хөрсөн бүрхэвч: Мэйжор дриллинг монгол ХХК-ийн химийн бодисын агуулахын талбайн хөрс нь талбайн хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар оффисын хажуу талаас авсан дээж бага зэрэг, агуулахын хойд талаас авсан дээж дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр хөрс байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь MNS:5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартыг хангаж байна.

Биологийн олон янз байдал: Химийн бодисын агуулах нь Хан-Уул дүүргийн үйлдвэрийн бүсэд байрлаж байгаа учраас амьтан, ургамлын аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд суурьших болжээ. Улаанбаатар хотод амьтны аймгаас хамгийн өргөн тархсан цөөн зүйлийн шувуу, шавж, хөхтөн судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн ба хээрийн бор шувуу, шаазгай, сохор элээ, хөх бор тагтаа, хар элээ, хөхтний дотроос хэргэлзий оготно, гэрийн хулгана, үлийн цагаан оготнууд байна.

Нийгэм эдийн засаг:

Улаанбаатар: 2024 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын хүн ам 1,659 мянга болж, өмнөх оноос 40.6 мянга буюу 2.45%-аар нэмэгдсэн байна. Нийт 47,117 өрхийн 1,659 хүн оршин сууж байна. Нийт хүн амын 48.3 % эрэгтэй, 51.7 % эмэгтэй байна.

Хан-Уул дүүргийн 3-р хороо: 2024 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүрэгт 76,857 өрхийн 265,793 хүн оршин сууж байна. Хан-Уул дүүргийн хүн амын тоо өмнөх жилээс 12 хувиар буюу 17,444 хүн нэмэгдэж өссөн үзүүлэлттэй байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүргийн 3-р хороонд 4,350 өрхийн 15,654 хүн оршин сууж байна.

Улаанбаатар хотын төсөв: Нийслэлийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2024 онд 3,103,605.5 төгрөг төлөвлөгдсөн энэ нь 2023 оноос 28.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 2024 онд 3,361,854 сая төгрөг буюу +100%-ийг зарцуулжээ.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Химийн бодисыг MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” стандартын дагуу хадгалаагүйн улмаас химийн бодисууд урвалд орж тэсэрч дэлбэрэх, галын аюул гарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа савыг хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээр сав цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарах, улмаар агуулахын агаарт тархах
- Агуулахын орчны тоосжилт болон химийн бодисын хадгалалт, ууршилтаас ялгарах хий нь агаар дахь тоосжилт ба агаарын чанарын найрлагыг тодорхой хэмжээгээр өөрчлөх.

3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Химийн бодисын агуулахын талбайн ихэнх хэсэг нь хатуу хучилттай бөгөөд барилга угсралтын ажил явагдахгүй тул хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй боловч захиалагчтай хийсэн гэрээгээр хөдөө орон нутагт өрөмдлөгийн үйл ажиллагааг хийж химийн бодис ашигласан тохиолдолд тээвэрлэлтийн явцад болон химийн бодисын асгаралт болж хөрсөн бүрхэвчид сөргөөр нөлөөлж болзошгүй.

3.3 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Агуулах нь Хан-Уул дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд байрлах учир ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.
- Химийн бодисын буруу хадгалалт тээвэрлэлт зэргээс үүдэн сав баглаа боодол задарч химийн бодис гадагш алдагдах, асгарч гоожих улмаар ургамлан нөмрөг бохирдож болзошгүй
- Агуулахын хашааны гадна талд тарьсан модны ургамлт муудах

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт химийн бодисын агуулахын үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Мэйжор дриллинг монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2024 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.10.29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2026 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд 15,576,000 төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1: 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	300,000
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,000,000
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,250,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,420,000
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	10,000,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,606,000
	<i>Нийт зардал</i>	15,576,000

4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэйжор дриллинг монгол ХХК нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2026 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Агуулахын хашааны гадна талд тарьсан модыг усалж, арчилгаа тордлогоо хийх
- Агуулахад хадгалдаг химийн бодис тус бүрийг ХАЛМ-ын дагуу тэмдэг тэмдэглэгээ нааж, зориулалтын тавиурт хадгалдаг
- Нэмэгдсэн бодисын хүрээнд химийн бодисын тусгай зөвшөөрлийг авсан
- Агуулахын агааржуулалтын системийн хяналтыг хийж, бүртгэл хөтөлж байна.

- Химийн бодисын хаягдал, үлдэгдлийг тогтмол цуглуулж, эрх бүхий байгууллагад нийлүүлж байна.
- Төслийн талбайд асгаралтын иж бүрдлийг тогтмол эх үүсвэрүүд дээр байршуулж байна.
- Нитийн цэвэрлэгээг жил бүр хийж байна.
- Асгаралтын журмыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.
- Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн бууруулах зорилгоор өнгөрсөн онд хийсэн хамгийн том ажил нь тоног төхөөрөмжийг цахилгаан болгосон явдал юм.

